

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

2015 оны 4-р сарын 29-ний өдөр

Багануур хот

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 18,00 цагт Монгол улс Улаанбаатар хот Багануур дүүрэг 3 хороо, Үйлдвэрийн хэсэгт байрлах Багануур ХК-ийн захиргааны төв байрны 2 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав. /Тооллогын комиссын нэгдүгээр тогтоолыг танилцуулав/

1. Компанийн нийт хувьцааны 75 хувийг эзэмшлийн төлөөлөл 15730770 ширхэг хувьцааг төлөөлж 20 тоот итгэмжлэлээр 99-р брокерийн пүүс дээр 4742 дугаартай Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Жавхлан, Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал Бямбасайхан, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичиг Д.Артаг
2. Жалцан овогтой Цэдэнсодном 502 ширхэг хувьцааг төлөөлж УБ49090113 регистртэй, 19-р брокерын пүүс 3715 бүртгэлийн дугаартайгаар
3. Дүгэрээ овогтой Түвшинтөгс 70 ширхэг хувьцааг төлөөлж УБ57092615 регистртэй, 29-р брокерын пүүс 4059 бүртгэлийн дугаартайгаар оролцож байна.

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс хуралд бүртгүүлж оролцож буй 15731342 ширхэг хувьцаа нь 20974360 ширхэг хувьцааны 75,002 хувийг бүрдүүлж байгаа тул хурал хуралдах ирц бүрдсэн болохыг мэдээллэв.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 4 сарын 27-ны өдрийн 20 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчийг томилсон. /Тогтоолыг танилцуулав/ Энэхүү тогтоолоор хувьцаа эзэмшигчийн төлөөлөгчөөр ТУЗ-ийн гишүүн Б.Жавхлан /хурал даргалагч/, Д.Артаг, Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарыг хавсралт ёсоор баталсугай. Эдгээр томилсон хүмүүсээс Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй болж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тушаалаар Тэргүүн дэд захирал Б.Ариунболд –д эрх олгох итгэмжлэл олгосон байна. /”Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/49 тоот тушаалыг уншиж танилцуулав./

Б.Жавхлан: Өнөөдрийн амгаланг айлтгая. Ингээд ээлжит хурлын ирц бүрдсэний дагуу хурлыг эхлээ. Хурлыг даргалж байгаагийн хувьд эхлээд хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг батлах нь зүйтэй. Хурлын дэгийг танилцуулья.

Д /д	ХУРЛЫН ДЭГ	ХУГАЦАА
1	Хурлын ирц бүртгэх /Тооллогын комисс/	13,00-14,00 цагт
2	Хурлын ирц мэдээллэх /Зохион байгуулах комисс/	5 минут

3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут
4	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут хэлэлцүүлэх
6	Хуралд оролцогсдын асуулт хариулт, санал, дүгнэлт авах	Хүн тус бүрээр 5 минут
7	Завсарлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах	15 минут
10	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналтай батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын зургаан асуудлыг танилцуулав.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах  
Илтгэгч: ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дамба
2. Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт  
Илтгэгч: Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлт  
ТУЗ-ийн Аудитын хорооны дарга Б.Осоргарав
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсөв  
Илтгэгч: ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дамба
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай  
Илтгэгч: ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох

Уг 6 асуудлаас гадна хэлэлцэх асуудал асуудал байвал саналаа хэлнэ үү.

Д.Дамба: Компанийн гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-д хандаж хүсэлт ирүүлсэн байна. Дулааны цахилгаан станц 4, 3, 2-ийн нийлүүлэлтийн үнийг 12-р сарын 3-ний өдрөөс нэмэхээр Эрчим хүчний зохицуулах хорооноос шийдвэр гарсан. Дулааны цахилгаан станц-4 ТӨХК-иас бусад бүх станцууд уг өдрөөсөө мөрдөж байгаа бөгөөд уг станц 2015 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсөн. Үүнд үнийн зөрүү гараад байгаа асуудлыг яаж шийдвэрлэх вэ? гэж гүйцэтгэх удирдлагаас асуудал оруулсан байгаа.

Б.Жавхлан: Батлагдсан асуудлын хүрээнд ярина уг асуудлаа дараагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх хэрэгтэй. Тооллогы комиссын хэлэлцэх асуудлаар санал хураалт явуулж, тогтоолоо танилцуулна уу?

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг танилцуулав. Тооллогын комисс хэлэлцэх асуудалд илээр санал хураахад 100% саналтай байна.

Б.Жавхлан: Ингээд батлагдсан асуудлууд дарааллын дагуу явагдана. Нэгдүгээр асуудлын талаар илтгэгч Д.Дамба танийг урьж байна.

**1-р асуудал:** Багануур ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дамба танилцуулав.

Б.Жавхлан: Сургалтыг компаниас хийж байгаа юу?

Д.Дамба: Тийм

Б.Жавхлан: 1 тн нүүрсийг станцад хэдэн төгрөгөөр өгч байгаа вэ?

Д.Дамба: Станцад 25 500 төгрөгөөр өгч байна.

Б.Жавхлан: Энэ өөрийн өртөг нь үү?

Д.Дамба: Тийм

Б.Жавхлан: Компани авлагаа 2014 онд хэр барагдуулсан бэ?

Ч.Очирлхам: Нийт 14 тэрбум төгрөгөөс 12-р сарын 31-ний байдлаар 7,2 тэрбум төгрөгний авлага үлдсэн байна. “ДЦС-4”ТӨХК 4 тэрбум, “БНДС”ТӨХК 2 тэрбум, “ДЦС-2”ТӨХК 1,6 тэрбум төгрөгийг авлага дийлэнх хувийг эзэлж байна.

Б.Жавхлан: 27500 төгрөгийн өртөг бууруулах боломж байгаа юу?

Д.Дамба: Багануур ХК, Шивээ овоо ХК гэсэн уурхайнууд нь төрийн өмч давамгайлсан байдаг тул нүүрсний үнийг төрөөс барьснаар эдийн засаг, санхүүгийн байдал нилээн хүндэрч байгаа. Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс техникийн зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд 27500 байгаа ч үүнээс доош буулгах боломжгүй.

Б.Жавхлан: Санал байвал хэлээд явъя. Байхгүй бол “Хангалттай” гэсэн үнэлгээг батлая.

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс тооллогын комиссын №3 тоот тогтоолыг танилцуулав. Илээр санал хурааж хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

Б.Жавхлан: Ингээд батлагдсан асуудлууд дарааллын дагуу хоёрдугаар асуудлыг Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам танилцуулна.

Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийн тухай Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам танилцуулав.

Б.Жавхлан: Яагаад энэ асуудлыг та танилцуулж байгаа юм бэ?

Ч.Очирлхам: Комисс томилсон учраас

Ариунболд: Аудит дүгнэлт хийж, ТУЗ-д хэлэлцсэн. Түүнийг л танилцуулна

Б.Жавхлан: Шалгалтын дүн биш, гаргасан дүгнэлтийг нь гэсэн үг үү? Батлахгүй сонсох юм байна. Хэзээ хийгдсэн дүгнэлт вэ?

Ч.Очирлхам: 3-р сарын 27-нд дүгнэлтээ ирүүлсэн.

Б.Жавхлан: Асуудалтай байгаа хэсгийг нь танилцуулаад явчих

Б.Жавхлан: Сонслоо баярлалаа

Б.Жавхлан: Ингээд батлагдсан асуудлууд дарааллын дагуу гуравдугаар асуудлыг Аудитын хорооны дарга Б.Осоргарав танилцуулна.

Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийн тухай Аудитын хорооны дарга Б.Осоргарав танилцуулав.

Б.Осоргарав: Дотоод хяналт шалгалтын албаны ажиллах чиглэлийг танилцууллаа.

Б.Жавхлан: ДХШАлба нь юу бүртгэснийг биш бүртгэлийг зөв хийсэн байгаа эсэхийг л хянадаг гэсэн үг үү?

Б.Осоргарав: Тийм. Юу бүртгэсэн байгааг хянах боломж байхгүй, тэгж хийсэн ажил ч байхгүй.

Б.Жавхлан: ДХША-нь хэнд тайлагнах вэ?

Б.Осоргарав: Гүйцэтгэх захиралд тайлагнана. ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргад тайлагнана.

Б.Жавхлан: Аудитын хороонд ажиллах журам бий юу?

Б.Осоргарав: Компанийн тухай хуульд зааж өгсөн байгаа. Хуулинд заасан 4 чиглэлээр Аудитын хороо ажилласан.

Б.Жавхлан: Аудитын хорооны дүгнэлтийг танилцуул. Зөрчилтэй юм байна уу? Аудитын хорооны дүгнэлт байхгүй байна.

Б.Осоргарав: Дүгнэлтийг тайланд тусгаагүй

Б.Жавхлан: Дүгнэлт байхгүй байхад энэ асуудалд шийдвэр гаргахгүй. 3-р асуудлыг шийдвэрлэхгүй.

Б.Жавхлан: Ингээд батлагдсан асуудлууд дарааллын дагуу дөрөвдүгээр асуудлыг Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам танилцуулна.

ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсвийн тухай ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дамба танилцуулав.

Б.Жавхлан: Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журмыг баталсан уу?

Д.Дамба: 2015 оны 03 дугаар сарын хурлаар баталсан.

Б.Жавхлан: ТУЗ нь 2014 онд хэдэн удаа хуралдсан бэ?

Д.Дамба: 9 удаа хуралдсан

Б.Жавхлан: Компанийн үйл ажиллагаатай хэдэн удаа танилцсан бэ?

Д.Дамба: Бүрэн бүрэлдэхүүнээр 2 удаа компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцсан.

Б.Жавхлан: Дүгнэлт дутмаг байна. Дүгнэлтийн найруулгыг дахин хянаж засварлаж, өөрчлөх хэрэгтэй. **2 дүгнэлтээ өөрчилж дахиж оруул!**

Багануур ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалингийн өөрчлөлтийн төсвийг ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дамба танилцуулав.

Б.Жавхлан: ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин хэдэн хувь нэмэгдэж байгаа вэ?

Д.Дамба: 40% орчим хувь нэмэгдсэн.

Б.Жавхлан: ТУЗ-ийн гишүүд их ажил хийчихээд түүнийгэ сайн дүгнээгүй байна. Энэ төсвийг батлах юм уу?

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс тооллогын комиссын №4 тогтоолыг танилцуулав.

Б.Жавхлан: Багануур ХК-ийн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд танилцуулна.

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд танилцуулав.

Б.Жавхлан: Дүрэмд оруулж буй өөрчлөлтийн талаар мэдээлэл авмаар байна.

Л.Ганболд: Дүрмийн 1-р хувилбарыг компани оруулж ирж байгаа бөгөөд 2-р хувилбарыг Эрдэнэс Монгол ХХК-иас дэвшүүлж байна

Б.Жавхлан: Хувь нийлүүлэгчдийн хуралруу оруулах нь зохимжгүй санагдаж байна. Жилд 1 удаа болдог хуралд оруулах нь буруу.

Ариунболд: 2 хувилбараа танилцуулж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдэхгүй бол хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал заавал хуралдуулая. 2014 оны 11 сард ирц бүрдээгүй улмаас хурал болоогүй. Ирц бүрдэхгүй бол ТУЗ-д эрх олгож шийдвэрлүүлдэг байх давхар хамгаалалт юм.

Л.Ганболд: Компанийн тухай хууль дээр ямар нэг заалт байхгүй. Тухайн компанийн дүрмэн дээр ТУЗ нь батлах уу ХЭХ нь батлах уу? гэдгийг өөрсдөө зохицуулдаг. Гүйцэтгэх

удирдлагын зүгээс бизнес төлөвлөгөө, томоохон төсвийн тодотгол хийх засвар орох асуудлыг ТУЗ дээр авахгүй бол ХЭХ-ийг 30 хоногийн өмнө зарлана. Өмнө нь хэлэлцэх асуудлаа батлана. Харин ХЭХ хуралдахгүй бол яах вэ? гэсэн асуудал юм.

Б.Жавхлан: Би компанийн төлөөллөөс санал авмаар байна.

Л.Шагдарсүрэн: Компанийн гүйцэтгэх удирдлагаас оруулж буй санал бол 1-р хувилбар байгаа. 9.3.7 дахь заалтыг хүчингүй болгуулах, ТУЗ-д компанийн бизнес төлөвлөгөөг батлах эрхийг олгох саналтай байгаа. Энэ юу вэ гэвэл өнгөрсөн 12-р сард хуралдахаар товлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал тодорхой шалтгааны улмаас хуралдаж чадахгүй, 2015 оны 1-р сарын 20-ний үеэр хуралдсан нь нилээд хүндрэл үүсгэсэн.

Б.Жавхлан: энэ эрх хэмжээг ТУЗ-д өгөх нь зүйтэй. Жилд 1 удаа болдог хуралд энэ асуудлыг оруулмааргүй байна.

Д.Түвшинтөгв: Би саналаа хэлье. Жилд 1 удаа хуралддаг хуралд бизнес төлөвлөгөөг батлахаар тохиромжгүй байна. Дулаархаар нүүрс захиалсан байгууллагууд захиалсан нүүрсээ авдаггүй. Тэгэхээр бид дахиад тодотгол хийх болдог. ТУЗ-өөр хэлэлцэх нь зөв гэж үзэж байна.

Б.Жавхлан: Миний бодлоор ТУЗ-д эрхийг нь өгөх нь зөв гэж үзэж байна. ТУЗ нь ХЭХ –д тайлагнадаг байх хэрэгтэй гэж үзэж байна. Өөр санал юу байна? саналаа хураая.

Д.Артаг: Миний хувьд ТУЗ-д эрх өгье гэдгийг дэмжиж байна.

Б.Жавхлан: Хувь нийлүүлэгчдийн хуралд ТУЗ тайлагнадаг байя. Харин энэ тайлангаа маш чанартаа тавьдаг байх. Энэ удаагийнх шиг биш! За саналаа хураая.

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс тооллогын комиссын №5 тогтоолыг танилцуулав.

Багануур ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20 974 360ш саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 15374342 ш саналын эрх бүхий хувь нийлүүлэгч оролцож, илээр санал хураахад компанийн дүрмийн өөрчлөлтийг 1-р хувилбараар баталсан 15,371,342 ш, татгалзсан түтгэлзсэн байхгүй. 100% саналаар 1-р хувилбарыг баталлаа.

Б.Жавхлан: Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох асуудлыг нэр дэвшүүлэх хорооны дарга Т.Батбаяр танилцуулна. Хувьцаа эзэмшигч болон тооллогын комиссын гишүүдээс бусад хүмүүсийг түр гарч байхыг хүсье.

ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга Т.Батбаяр ердийн гишүүнд нэр дэвшсэн хүмүүс танилцуулав.

Т.Батбаяр: Компанийн тухай хууль болон дүрмээ ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар эхэлж дараагаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дуусгавар болох зохицуулалттай.

Б.Жавхлан: ТУЗ-ийн гишүүдтэй танилцъя. /танилцав/ Яг албан тушаалаараа томилогдоод, тухайн албан тушаал дээр байхгүй байгаа холбогдолгүй болсон саналууд дээр энэ асуудал яригдана. Бүтнээр нь ярихгүй.

Ариунболд: Үгүй. ТУЗ-ийн гишүүдийг Ерөнхий сайд үүрэг даалгавар өгсний дагуу сонголт хийгээд хараат бусаас бусад 9 хүний нэр ирсэн. Үүнээс 4-ийг нь сонгоод, компанийн тухай хууль, Эрдэнэс Монгол компанийн дүрмийн дагуу бүх асуудлыг шийдвэрлээд нэрсийг өгсөн. Тийм учир маргах асуудал байхгүй. Нэрс орж ирсэн. Ерөнхий сайд болон Баярцогт дарга үүрэг өгсөн.

Б.Жавхлан: Тийм асуудал байхгүй. Та хурал битгий үймүүлээд бай. Энэ асуудлыг шийдвэрлэх хүмүүс нь үлдээд байх ёсгүй хүмүүс нь хурлаа орхиод гарч болно.

Батбаяр: Компанийн тухай хуулийн дагуу нэр дэвшүүлэх хороо нь Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд төлөөлөгч зөвлөлийн гишүүддээ сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр санал оруулахаар хуулинд заасан учир Эрдэнэс Монгол компани нь Багануур ХК-ийн 75% буюу 15730770 ш төрийн мэдлийн хувьцааг эзэмшдэг. Үүнийхээ дагуу гүйцэтгэх захирал Бямбасайхны гарын үсэгтэй ердийн гишүүн дор дурьдсан 12 хүнийг нэр дэвшүүлэх саналтай байна гэсэн албан тоотыг танилцуулъя.

Төрийн төлөөлөл /Эрдэнэс монголын төлөөлөл 7 гишүүн/: 1. Ариунболд

2. Болд 3. Л.Ганболд 4.Батбаяр 5.Д.Чойжил 6.Хуягбаатар 7.Мэргэнбаяр

Б.Жавхлан: Одоо яг ТУЗ хэдэн гишүүнтэй байгаа вэ?

Батбаяр: ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх нь эрх жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хүчинтэй байна. энэ хурлаар бүрэн эрх нь дуусгавар болж байна. Тиймээс шинээр хувьцаа эзэмшиж байгаа байдлаар нь санал оруулах ёстой. Тэр дагуу Эрдэнэс Монгол нь 75% ийг эзэмшиж байгаа учир 7 хүнийг нэр дэвшүүлж байгаа юм. Дээрх нэр дэвшигчдийг компанийн тухай хуулийн 81,5-р зүйлд заасны дагуу сонгон шалгаруулалт хийж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлж өгнө үү. Хүндэтгэсэн Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал Бямбасайхан гэсэн албан тоотын дагуу энэ 7 хүний нэрийг дэвшүүлж үүний дагуу санал хураана. / Эрдэнэс Монгол ХХК-ийн 2015 оны 04 дүгээр 29-ний 01/202 тоот албан бичгийг танилцуулав/

Б.Жавхлан: Хараат бус гишүүнийг яах вэ

Батбаяр: Төрийн төлөөллөө л танилцуулна.

Б.Жавхлан: Би бол энэ зарчмаар явуулна. 7 хүн хэвээрээ байна. Хуучин 6 байсан. Тэндээс Пүрэвбаатар, Жигжид, Бэхбат нар ТУЗ-д шууд ажиллах боломжгүй байгаа тул энэ 3 хүний орон тоонд нэр дэвшүүлэх саналтай байна.

Ариунболд: Үгүй. Жавхлан. Компанийн тухай хуулийн 34.1.1, Эрдэнэс Монгол компанийн дүрмийн 9-р зүйлд заасны дагуу Багануур, Шивээ овоо ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага гарсан. Хууль дүрмийн дагуу энэ асуудлууд орж ирж байгаа. 2-рт:

Шийдлийн засгийн газар ТУЗ-д байгаа төрийн төлөөллийг буулгах зарчмаар асуудлуудыг шийдвэрлэнэ гэсэн. Энэ шийдвэрийн дагуу уг асуудал шийдэгдэж байгаа. Ерөнхий сайд өчигдөр шууд үүрэг даалгавар өгөөд бүгдийг солино гэдгийг хэлсэн. Баярцогт байсан. Өчигдөр биднийг ордонд хүлээн авч хэлсэн. Мессежээр байна.

Б.Жавхлан: Уучлаарай. Дүрэм журмын дагуу явагдана. Миний зарчим байгаа бүрэлдэхүүнээр нь үргэлжлүүлэх, харин орон тоо гарсан 3 хүний оронд санал оруулах зарчмаар явна.

Д.Артаг: Дараагийн хурал хүртэл ТУЗ эрхээ хэрэгжүүлнэ. Үүгээр дуусгавар болно гэж танилцуулж байна. Манай яамны хувьд Уул Уурхайн Яамны төрийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дарга байсан. Дээрээс нь ахлах мэргэжилтэн Дамба мэргэжлийн дагуу ТУЗ-д байсан. УУЯ-аас 2 хүн байсан. Би яг Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас барьж байгаа байр суурийг албан ёсоор гар дээрээ үзээгүй. Ийм яриа явагдаж байна гэдгийг албан бусаар авсан. Албажуулж хараагүй учир үүнд итгэхгүй байна. 2-рт: Эрдэнэс Монгол ХХК-ийн гаргах асуудал гэхдээ УУЯ-аас ТУЗ-д төлөөлөл байх ёстой. Энэ бол Дамбад надад зориулагдсан хэрэг биш. Салбарын яамны хувьд манай сайдын хувьд Ерөнхий сайд, Баярцогттой уулзаж салбарын яамны бүрэлдэхүүн ТУЗ-д байх ёстой гэж илэрхийлсэн. Өнөөдөр ч мөн адил сайд ийм чиглэл өгсөн учир УУЯ-ны төлөөлөл байх ёстой гэсэн байр суурьтай байна.

Б.Жавхлан: 4 хүний асуудал дээр би санал авна. Бусад гишүүд нь хэвээрээ. Би 3 хүн нэр дэвшүүлнэ. 1. Төрийн өмчийн хорооны ахлах мэргэжилтэн Нарангэрэл 2. Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын газрын дарга Оюунчимэг 3. Д.Артаг дарга, Хараат бус гишүүн дээр Ганбат гишүүн. Бусад гишүүд бол хэвээрээ.

Б.Ариунболд: Үгүй, үгүй. Бид дүрмийн дагуу явж байгаа.

Б.Жавхлан: Бид ч дүрмийн дагуу ажиллаж байна. тооллогын комисс ажлаа хий. Энгийн 3, хараат бус дээр 1 хүний тухай. Дүрмийн дагуу дэвшүүлж байна. саналаа хураая.

Ариунболд: Хурал даргалж буй хүн 100% эзэмшигч биш. Эрдэнэс Монгол 75% -ийг эзэмшиж байгаа гэдгийг сануулъя. Хувьцаа эзэмшигчийн хурлын дарга дангаараа нэр дэвшүүлэх эрхгүй.

Д.Түвшинтөгс: Тооллогын комисс саналыг кумлятив аргаар санал хураана, нууцаар санал хураана. Бидний дүрэм зөрчигдөх гээд байна. 2-рт Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг Эрдэнэс Монгол ХХК өөрөө томилчихоод санал зөрөөд байгаад гайхаж байна.

Б.Ариунболд: Дарга гэдэг чинь 1 саналын эрхтэй. Хурлын дарга санал өгөх эрхгүй

Б.Жавхлан: Хэн санал өгөх эрхтэй юм

Т.Батбаяр: Хувьцаа эзэмшигч.

Б.Жавхлан: Хувьцаа эзэмшигчийг хэн төлөөлж байгаа юм.

Б.Ариунболд: Хурал тэргүүлж байгаа Б.Жавхлан, Д.Артаг, Б.Ариунболд



Б.Жавхлан: УУЯ-аас 2 гишүүн нэр дэвшүүл

Д.Артаг: 2 гишүүнд: Д.Артаг, Д.Дамба нарыг дэвшүүлье

Б.Жавхлан: Миний хувьд уг 2 хүнийг дэмжинэ.

Б.Жавхлан, Б.Ариунболд, Д.Артаг нарын саналыг тооллогын комисс хүлээн авав.

Б.Жавхлан: Эрчим хүчний яамнаас ирсэн бичгийг үзүүлээч.

Компанийн нийт хувьцааны 75 хувийг эзэмшлийн төлөөлөл 15730770 ширхэг хувьцааг төлөөлж 20 тоот итгэмжлэлээр 99-р брокерийн пүүс дээр 4742 дугаартай Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Жавхлан, Д.Артаг болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Тэргүүн дэд захирал Б.Ариунболд нар зөвшилцөв.

Д.Түвшинтөгс: Тооллогын комиссын хурлын тогтоол. 4-р сарын 29-ний өдөр №6. ТУЗ-ийн Ердийн гишүүн сонгох санал хураалтын дүнгийн тухай.

Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20 974 360ш саналын эрх бүхий 27266680 ш саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 3 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч оролцсон байна. үүнээс комплятив аргаар нийт саналын 141982875 саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох саналын 3ш хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй хуудас байхгүй. Танилцуулбал:

1. Б.Ариунболд 15,730,770 санал
2. Д.Болд 15,731,482
3. Н.Хуягбаатар 15,730,770
4. Г.Мэргэнбаяр 15,730,770
5. Нарангэрэл 15,730,770
6. Л.Оюунчимэг 15,731,272
7. Д.Артаг 15,731,272
8. Г.Батдорж 15,731,342
9. О.Болор-Эрдэнэ 15,731,341 санал авч сонгогдсон байна.

Тооллогын комиссын дарга Д.Түвшинтөгс

Тооллогын комиссын тогтоол №7. ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүнгийн тухай.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360ш хувьцаа эзэмшигч бүхий 272,666,680ш саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 204,507,445 ш саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцож, үүнээс ТУЗ-ийн гишүүдийг сонгох комплятив аргаар нийт саналын эрх 62925361 саналаар ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалт явуулж 3ш саналын хуудсаар санал хураалт явуулсан байна.

Хүчингүй саналын хуудас байхгүй. Сонгогдсон байдлыг танилцуулбал:

ТУЗ-ийн хараат бус гишүүн: 1. Г.Ёндонгомбо 15,730,770

Т.Батбаяр: Хурал тэргүүлэгчид нэгдсэн 1 санал өгөх эрхтэй.

Д.Түвшинтөгс: Нэр дэвшүүлэх хороо бүх гишүүдийн нэрийг өгөх ёстой. Гэтэл Эрдэнэс Монгол ХХК төлөөлөл 7 хүнээс өөр бусад нэр дэвшигчдийг дэвшүүлээгүй.

Б.Ариунболд: Би бол Уул уурхайн яам, Эрчим хүчний яамнаас тус бүр нэг нэг хүн байх ёстой гэсэн.

Д.Артаг: Би бол УУЯ-аас 2 төлөөлөл байна гэдэгт хатуу байр суурьтай байна

Б.Ариунболд: Би бол УУЯ, ЭХЯ-аас төлөөлөл байх ёстой гэсэн. ЭХЯ-аас албан ёсоор нэр нь ирсэн. Албан тоотоор.

Б.Жавхлан: Би нэр дэвшүүлэх эрхтэй.

Б.Ариунболд: Үгүй. Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлэх эрхтэй. Бүх юм хууль зөрчиж байна. Нэрсээ бэлтгээд нэр дэвшүүлнэ. Хуулиндаа заасан. Хэн нэгэн хүний хэрэг биш. Дарга нэр дэвшүүлдэг хууль байхгүй.

Б.Жавхлан: Тооллогын комисс ажлаа хий

Б.Ариунболд: Д.Артаг чи бид 3 нийлж байж 1 саналын эрхтэй. 15 сая хувьцаа 1 саналын эрхтэй. Д.Артаг, Б.Жавхлан та 2 дангаараа санал өгөх эрхгүй.

Д.Түвшинтөгс: Тооллогын комисс ажиллахад хүндрэлтэй байна. Нэр дэвшигчдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь 13 хүнийг санал болгох хэрэгтэй. Гэвч 7 хүнийг л Эрдэнэс Монгол ХХ-иас санал болгож байна. 15 сая хувьцаа 1 санал өгөх эрхтэй. Саналын хуудсыг бүрэн бичих эрхтэй.

Б.Ариунболд: Нэр дэвшүүлэх хорооны бүрэн эрхээ хэрэгжүүл.

Б.Жавхлан: Саналын хуудсыг явуул. Хурал удирдсан даргад эрхийг өгсөн. Жигжид, Бэхболд, Пүрэвбаатар нарын оронд нэр дэвшүүлэх гишүүдийг танилцуул. Би хурал даргалж байгаа хүний хувьд санал өгөх эрхтэй гэж үзэж байна.

Б.Ариунболд: Хурлын дарга санал өгөх эрхгүй. 3 хүн 1 саналын эрхтэй. Бидний санал нэгдэж байж гишүүдийг сонгох эрхтэй. Энэ бол хууль бус шүү!

Д.Түвшинтөгс: Иж бүрнээр нь нэр дэвшүүлэх ёстой.

Б.Наранцэцэг: Санал хураалт нууцаар явагдах ёстой. Гэвч санал ил болсон. Мөн 3 төлөөлөгч нийлж байж 1 саналын эрхтэй гэсэн байдаг тул санал хураалтыг тооллогын комисс үргэлжлүүлэх бололцоогүй байна.

Б.Жавхлан: Тус тусад нь гаргасан саналууд дээр нь санал хураая. Ердийн 7 гишүүн, хараат 4 гишүүн.

Д.Артаг: УУЯ-аас 2 гишүүнийг томилуулах, бусдыг нь хуучин бүрэлдэхүүнээр үлдээх саналтай байна.

2. Т.Наран 15,731,342  
3. Б.Осоргарав 15,731,342  
4. Б.Ганбат 15,731,342 саналаар сонгогдсон байна.

Тооллогын комисс, нарийн бичгийн дарга.

Б.Жавхлан: Хурлаас гарах тогтоолын төслөө танилцуулна уу.

Л.Шагдарсүрэн: 1-р тогтоолын төслийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.

2-р тогтоолын төслийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.

3-р тогтоолын төслийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.

4-р тогтоолын төслийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.


5-р тогтоол тогтоолын төслийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 1 хувилбарыг 100%-ийн саналаар батлав.


6-р тогтоолын төслийг хавсралтын хамт танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс илээр санал авч 100%-ийн саналаар батлав.

Б.Жавхлан: Ээлжит хурал зургаан асуудлыг хэлэлцэж нийт 6 тогтоол гаргалаа.

Ж.Цэрэнсодном: Надад нэг санал байна. Жижиг хувьцаа эзэмшигчидээ бодох хэрэгтэй. Тэдний эрх ашгийг бодоорой .

Хурлын дарга Б.Жавхлан 21,30 цагт хурлыг хааж Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн , ээлжит хурал амжилттай болж дууссан тухай мэдэгдэж хуралд оролцогсдод ажлын амжилт хүслээ.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн. Хурал зохион байгуулах комиссын гишүүн  Д.Ганчимэг  
О.Цолмонцэцэг

Хурлын тэмдэглэлтэй танилцсан. Хурлын дарга  Б.Жавхлан